



ФОКСКОН

олон үндэстнээ танилцуулж байна



УКРАИН

Украины уламжлалт хоол Борщ, Тагтаа зэргийг амтлаарай!

Борщ

Орц

Гахайн сүвээний мэх
2-3 ш төмс
300 g шинэ байцай
1 лааз улаан лоолийн нухаш, эсвэл 2 ш лооль
1 ш сонгино
1 чимх давс
1 ш томхон лууван
Шарахад зориулсан ургамлын тос
1 амны халбага шөл амтлагч
1 чимх нунтаг перец
1 ш лаврын навч
1 аяга исгэлэн цөцгий
1 ш томхон хүрэн мэнжин
1 багц яншуй



Хийх арга: Хөшиглөсөн мэх, дөрвөлжилж хэрчсэн төмс, жижиглэж хэрчсэн байцаагаа тогоондоо хийж зөөлөн гал дээр чанана. Лаврын навч, шөл амтлагчаа нэмнэ. Хүрэн мэнжинг хальстай нь тусад нь саванд чанаж болгоод том нүхтэй үрүүлээр үрнэ. Хайруулын тавганд ургамлын тос хийж халаагаад сонгино, үрсэн лууванг хийж хуураад дээр нь хүрэн мэнжин нэмнэ. Давс, перец зэргээр амталж, улаан лоолийн нухаш, 2 халбага исгэлэн цөцгий зэргийг нэмж хутгаад таглаж зөөлөн гал дээр чанана. Дараа нь тогоотой зүйл дээрээ хийж хольж хутгаад 7-10 минут чанана. Галаа унтрааж шөлөө хэсэг байлгавал илүү амттай болно. Таваглахдаа халбага исгэлэн цөцгий, жижиглэж хэрчсэн яншуйгаар амталж чимнэ.

Байцайны ороомог

Орц

1 ш цагаан байцай
500 g татсан мэх (үхэр гахайн холимог)
500 g цагаан будаа
1 лууван
1 сонгино
Ургамлын тос
2 халбага улаан лоолийн нухаш
давс
нунтаг перец
шөл амтлагч



Хийх арга: Буцалж буй усанд байцайгаа бүтнээр нь хийгээд, навч навчаар нь салгана. Байцайны навчны хатуу хэсгүүдийг нь огтлоод саванд хийж тавина. Байцайнд ороох шанзаа бэлдэнэ. Дөрвөлжилж хэрчсэн сонгино, үрсэн лууванг тосонд хуурна. Цагаан будаагаа хуурч хөргөөд татсан мэх, хуурсан сонгино луувантай хамт том саванд хийж хутгана. Давс, перец, шөлний амтлагчаар амталж гараараа сайтар базаж холино. Шанзаа байцайны навчинд ороож бооно. Том савны ёроолд үлдсэн байцайгаа дэвсээд ороомгуудаа дээр нь шахаж өрнө. 2 халбаг улаан лоолийн нухаш хийж хутгасан давстай ус дээр нь хийнэ. Усны хэмжээ савны дундуур хүртэл хэмжээтэй байна. Зөөлөн гал дээр 30-40 минут (байцайны ороомгийн тооноос шалтгаална) чанана. Таваглахдаа мөөгний сүүмс эсвэл дан цөцгий нэмнэ.

Сайхан хооллоорой



FOXCONN